ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/132/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъясүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/172

танай ______________-ны № ____________________-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ч.БАЯРСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв буурч батлагдсантай холбоотой байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, санхүүжилт, орлогын эх үүсвэрийг зөв зохион байгуулан, нэн тэргүүнд эмч, ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх, эм эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг бууруулах зэрэг арга хэмжээг авч ажиллах талаар Эрүүл мэндийн яамны 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 2/4931 дүгээр албан бичгээр ажлын чиглэл ирсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас шалтгаалж 2025 оны 10, 11, 12 дугаар сарын 121,458.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй авлага үүссэн байна.

**Аудитын гол асуудал**

Төв аймгийн Заамар сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлаар тус сумын Эрүүл мэндийн газрын ажилчдын байрны их засвар, өргөтгөлийн барилгын ажилд нийт 49,590.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, тайлант оны 9 дүгээр сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт бүхий нийт 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг

4126020217

94,4 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **437,835,137.10** | **274,073,485.58** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **37,974,775.78** | **89,507,643.45** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **37,974,775.78** | **89,507,643.45** |
| **3121** | **Төгрөг** | **37,974,775.78** | **89,507,643.45** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 37,974,775.78 | 89,507,643.45 |
| **33** | **АВЛАГА** | **340,404,686.87** | **121,458,315.80** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 340,404,686.87 | 121,458,315.80 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **59,455,674.45** | **63,107,526.33** |
| **351** | **Түүхий эд материал** | **24,258,192.26** | **34,979,872.04** |
| 35130 | Эм боох материал | 24,258,192.26 | 34,979,872.04 |
| **354** | **Хангамжийн материал** | **35,197,482.19** | **28,127,654.29** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 38,800.00 | 433,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 124,506.00 | 185,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 1,890,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,579,530.00 | 5,015,370.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 27,454,646.19 | 20,603,784.29 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,409,536,246.52** | **2,333,537,035.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,409,536,246.52** | **2,333,537,035.67** |
| **392** | **Биет хөрөнгө** | **2,401,473,446.52** | **2,325,474,235.67** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,267,901,313.00 | 2,317,491,368.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (378,784,644.63) | (500,023,289.19) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 125,830,000.00 | 125,830,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (67,976,111.14) | (78,116,805.62) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 510,056,315.68 | 586,138,179.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (175,542,530.66) | (261,088,648.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 167,416,390.06 | 201,398,290.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (68,988,765.79) | (87,472,131.25) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,961,480.00 | 3,961,480.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (900,000.00) | (1,144,207.78) |
| 39217 | Ном | 18,500,000.00 | 18,500,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **8,062,800.00** | **8,062,800.00** |
| 39301 | Програм хангамж | 435,000.00 | 435,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (435,000.00) | (435,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,062,800.00 | 8,062,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,847,371,383.62** | **2,607,610,521.25** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,847,371,383.62** | **2,607,610,521.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,847,371,383.62** | **2,607,610,521.25** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 272,050,531.95 | 272,050,531.95 |
| 51101 | Өмч: - төрийн | 272,050,531.95 | 272,050,531.95 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **2,304,138,462.94** | **2,064,377,600.57** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,304,138,462.94 | 2,304,138,462.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (239,760,862.37) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 271,182,388.73 | 271,182,388.73 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,847,371,383.62** | **2,607,610,521.25** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,690,181,959.19** | **1,989,122,323.95** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **831,163,363.28** | **214,115,313.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **831,163,363.28** | **214,115,313.65** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,502,400.00 | 91,530,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,502,400.00 | 87,583,900.00 |
| 120017 | | 00.00 | 00.00 |
| 120018 | | 00.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,859,018,595.91** | **1,775,007,010.30** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **132,842,500.00** | **114,398,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 132,842,500.00 | 114,398,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **1,726,176,095.91** | **1,660,608,210.30** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,726,176,095.91 | 1,660,608,210.30 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,851,004,963.67** | **2,206,943,938.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,851,004,963.67** | **2,206,943,938.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,802,960,735.43** | **2,069,142,142.89** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,002,679,115.83** | **1,190,045,313.23** |
| 210101 | Үндсэн цалин | 724,820,468.01 | 696,367,554.39 |
| 210102 | Нэмэгдэл | 270,379,647.82 | 419,062,149.64 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,479,000.00 | 6,049,440.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 68,566,169.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **125,833,002.23** | **149,585,987.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,120,938.86 | 104,699,178.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,200,562.12 | 12,129,875.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,216,577.41 | 6,165,492.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,015,985.24 | 5,637,336.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,278,938.60 | 20,954,105.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **91,403,140.52** | **95,483,454.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,259,143.45 | 21,766,396.52 |
| 210302 | Түлш, халаалт | 76,656,811.47 | 73,229,872.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 487,185.60 | 487,185.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **77,258,865.00** | **90,458,534.80** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,609,600.00 | 8,923,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 40,247,500.00 | 38,334,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,234,050.00 | 4,439,634.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 17,985,775.00 | 25,905,432.30 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,181,940.00 | 12,855,818.50 |
| **2105** | **Нормативт зардал** | **194,185,404.82** | **188,021,810.72** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 144,250,885.82 | 120,505,640.72 |
| 210502 | Хоол, хүнс | 43,276,019.00 | 55,574,170.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,658,500.00 | 11,942,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **49,501,550.00** | **65,230,654.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,425,450.00 | 1,712,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,949,750.00 | 7,872,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 41,126,350.00 | 55,646,554.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,698,000.00** | **12,735,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,698,000.00 | 12,735,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,788,098.00** | **3,125,498.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 8,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 292,350.00 | 299,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 255,748.00 | 251,648.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 108,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,532,000.00 | 2,458,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **255,613,559.03** | **274,455,890.05** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,427,900.00 | 38,802,860.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 227,185,659.03 | 235,653,030.05 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,044,228.24** | **137,801,795.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,104,868.76** | **121,341,450.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 23,261,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 59,892,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,104,868.76 | 38,187,550.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **38,939,359.48** | **16,460,345.88** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,939,359.48 | 16,460,345.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **839,176,995.52** | **(217,821,614.82)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 21,939,247.55 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 21,939,247.55 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | (21,939,247.55) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **839,176,995.52** | **(239,760,862.37)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,571,346,552.04** | **2,085,484,281.37** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,502,400.00** | **91,530,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,502,400.00** | **91,530,900.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **3,502,400.00** | **91,530,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,947,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,502,400.00 | 87,583,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,567,844,152.04** | **1,993,953,381.37** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **132,842,500.00** | **114,398,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 132,842,500.00 | 114,398,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **1,435,001,652.04** | **1,879,554,581.37** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,435,001,652.04 | 1,879,554,581.37 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,581,831,824.66** | **1,975,154,413.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,581,831,824.66** | **1,975,154,413.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,533,787,596.42** | **1,837,352,617.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,003,374,821.78** | **1,190,045,313.23** |
| 210101 | Үндсэн цалин | 587,249,233.72 | 696,367,554.39 |
| 210102 | Нэмэгдэл | 343,032,887.54 | 419,062,149.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,993,783.64 | 6,049,440.00 |
| 210104 | Урамшуулал | 66,098,916.88 | 68,566,169.21 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,726,079.12** | **149,585,987.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,904,983.57 | 103,103,938.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,104,589.99 | 12,129,875.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,188,792.20 | 6,165,492.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,705,542.66 | 5,637,336.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,822,170.70 | 22,549,345.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **91,403,140.52** | **95,483,454.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,259,143.45 | 21,766,396.52 |
| 210302 | Түлш, халаалт | 76,656,811.47 | 73,229,872.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 487,185.60 | 487,185.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **75,271,140.00** | **82,773,224.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,971,700.00 | 9,176,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,400,000.00 | 40,224,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,071,600.00 | 4,439,634.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,304,550.00 | 14,982,950.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,523,290.00 | 13,950,290.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **153,805,317.00** | **198,493,330.50** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 102,217,838.00 | 133,541,320.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 44,928,979.00 | 53,010,010.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,658,500.00 | 11,942,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **50,293,100.00** | **66,253,950.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 890,000.00 | 2,621,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,949,750.00 | 7,872,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 42,453,350.00 | 55,760,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,698,000.00** | **12,735,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,698,000.00 | 12,735,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,788,098.00** | **3,125,498.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 292,350.00 | 299,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 255,748.00 | 259,648.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 108,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,532,000.00 | 2,458,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **28,427,900.00** | **38,856,860.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,427,900.00 | 38,856,860.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,044,228.24** | **137,801,795.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,104,868.76** | **121,341,450.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 23,261,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 59,892,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,104,868.76 | 38,187,550.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **38,939,359.48** | **16,460,345.88** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,939,359.48 | 16,460,345.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(10,485,272.62)** | **110,329,867.67** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **22,490,000.00** | **58,797,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,490,000.00** | **58,797,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 22,490,000.00 | 58,797,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 22,490,000.00 | 58,797,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(22,490,000.00)** | **(58,797,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **(32,975,272.62)** | **51,532,867.67** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 71,361,265.56 | 37,974,775.78 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 37,974,775.78 | 89,507,643.45 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 272,050,531.95 | 363,823,252.68 | 16,337,117.76 | 652,210,902.39 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **272,050,531.95** | **363,823,252.68** | **16,337,117.76** | **652,210,902.39** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 961,530,227.15 | 961,530,227.15 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **2,304,138,462.94** | **2,847,371,383.62** |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **2,304,138,462.94** | **2,847,371,383.62** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **2,304,138,462.94** | **2,847,371,383.62** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (239,760,862.37) | (239,760,862.37) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,050,531.95** | **271,182,388.73** | **2,064,377,600.57** | **2,607,610,521.25** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,515,808,000.00** | **2,069,023,935.49** | **446,784,064.51** | **82.24** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **114,398,800.00** | **97,938,454.12** | **16,460,345.88** | **85.61** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 114,398,800.00 | 97,938,454.12 | 16,460,345.88 | 85.61 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,209,609,600.00** | **1,879,554,581.37** | **330,055,018.63** | **85.06** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 2,209,609,600.00 | 1,879,554,581.37 | 330,055,018.63 | 85.06 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **191,799,600.00** | **91,530,900.00** | **100,268,700.00** | **47.72** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 191,799,600.00 | 91,530,900.00 | 100,268,700.00 | 47.72 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,515,808,000.00** | **2,017,491,067.82** | **498,316,932.18** | **80.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,515,808,000.00** | **2,017,491,067.82** | **498,316,932.18** | **80.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,298,177,200.00** | **1,896,149,617.82** | **402,027,582.18** | **82.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,435,030,000.00** | **1,190,045,313.23** | **244,984,686.77** | **82.93** |
| 210101 | Үндсэн цалин | 857,336,000.00 | 696,367,554.39 | 160,968,445.61 | 81.22 |
| 210102 | Нэмэгдэл | 335,694,000.00 | 419,062,149.63 | -83,368,149.63 | 124.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,000,000.00 | 6,049,440.00 | 19,950,560.00 | 23.27 |
| 210104 | Урамшуулал | 216,000,000.00 | 68,566,169.21 | 147,433,830.79 | 31.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **190,593,400.00** | **149,585,987.97** | **41,007,412.03** | **78.48** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,876,900.00 | 103,103,938.54 | 24,772,961.46 | 80.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,937,000.00 | 12,129,875.14 | 1,807,124.86 | 87.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,937,000.00 | 6,165,492.80 | 7,771,507.20 | 44.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,968,500.00 | 5,637,336.33 | 1,331,163.67 | 80.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,874,000.00 | 22,549,345.16 | 5,324,654.84 | 80.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **109,398,800.00** | **95,483,454.12** | **13,915,345.88** | **87.28** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,321,300.00 | 21,766,396.52 | -2,445,096.52 | 112.65 |
| 210302 | Түлш, халаалт | 89,677,500.00 | 73,229,872.00 | 16,447,628.00 | 81.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 487,185.60 | -87,185.60 | 121.80 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **116,049,100.00** | **82,773,224.00** | **33,275,876.00** | **71.33** |
| 210401 | Бичиг хэрэг | 11,598,300.00 | 9,176,350.00 | 2,421,950.00 | 79.12 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 63,450,800.00 | 40,224,000.00 | 23,226,800.00 | 63.39 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,000,000.00 | 4,439,634.00 | 4,560,366.00 | 49.33 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,000,000.00 | 14,982,950.00 | 17,050.00 | 99.89 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,000,000.00 | 13,950,290.00 | 3,049,710.00 | 82.06 |
| **2105** | **Нормативт зардал** | **242,000,000.00** | **198,493,330.50** | **43,506,669.50** | **82.02** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 150,000,000.00 | 133,541,320.50 | 16,458,679.50 | 89.03 |
| 210502 | Хоол, хүнс | 70,000,000.00 | 53,010,010.00 | 16,989,990.00 | 75.73 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 22,000,000.00 | 11,942,000.00 | 10,058,000.00 | 54.28 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **147,154,700.00** | **125,050,950.00** | **22,103,750.00** | **84.98** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 74,000,000.00 | 61,418,500.00 | 12,581,500.00 | 83.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 10,000,000.00 | 7,872,100.00 | 2,127,900.00 | 78.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 63,154,700.00 | 55,760,350.00 | 7,394,350.00 | 88.29 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,500,000.00** | **12,735,000.00** | **765,000.00** | **94.33** |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,500,000.00 | 12,735,000.00 | 765,000.00 | 94.33 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,757,000.00** | **3,125,498.00** | **631,502.00** | **83.19** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 00.00 | 576,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 299,350.00 | 650.00 | 99.78 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 260,000.00 | 259,648.00 | 352.00 | 99.86 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 108,500.00 | 23,500.00 | 82.20 |
| 210807 | Газрын төлбөр | 16,000.00 | 00.00 | 16,000.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 2,473,000.00 | 2,458,000.00 | 15,000.00 | 99.39 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **40,694,200.00** | **38,856,860.00** | **1,837,340.00** | **95.49** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,694,200.00 | 38,856,860.00 | 1,837,340.00 | 95.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **217,630,800.00** | **121,341,450.00** | **96,289,350.00** | **55.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **217,630,800.00** | **121,341,450.00** | **96,289,350.00** | **55.76** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,736,800.00 | 23,261,900.00 | 30,474,900.00 | 43.29 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 93,894,000.00 | 59,892,000.00 | 34,002,000.00 | 63.79 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 70,000,000.00 | 38,187,550.00 | 31,812,450.00 | 54.55 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **37,974,775.78** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **89,507,643.45** | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 926,514.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 3,499.1 мянган төгрөгийн шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд биет бус хөрөнгө /газар эзэмших эрх/ 292.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон.

Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг 839,115.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Төв аймгийн Заамар сумын эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар ажилтнуудад олгосон мөнгөн шагналын 453.7 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар тооцож тайланд тусгаагүй.

Туслах үйл ажиллагааны 83,153.9 мянган төгрөгийн орлогыг дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилтээр бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 12,193.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 12,193.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 12,193.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 22,069.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Санхүүгийн тайлантай холбоотой асуудал***

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3 "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

2. ***Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 382 ширхэг 173,549.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ. гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

<u>Өгсөн зөвлөмж</u>: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх.

### 3. *Зардлын данстай холбоотой асуудал*

<u>Илрүүлэлт</u>

Бараа үйлчилгээний бусад зардлаас 12,193.0 мянган төгрөгийн хичээл, сургалт зохион байгуулсан.

Энэ нь Төвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар"-тай нийцээгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** *\/мянган төгрөгөөр/*

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 3,499.1 мянган төгрөгийн шилжүүлэн авсан хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн. | 1 | 3,499.1 | | | 1 | 3,499.1 | 1 | 3,499.1 | | |
| 2 | Санхүүгийн үр дүнгийн тайланд биет бус хөрөнгө (газар эзэмших эрх) 292.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон. | 1 | 292.4 | | | 1 | 292.4 | 1 | 292.4 | | |
| 3 | Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг 839,115.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 839,115.7 | | | 1 | 839,115.7 | 1 | 839,115.7 | | |
| 4 | Төв аймгийн Заамар сумын эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар ажилтнуудад олгосон мөнгөн шагналын 453.7 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар тооцож тайланд тусгаагүй. | 1 | 453.7 | | | 1 | 453.7 | 1 | 453.7 | | |
| 5 | Туслах үйл ажиллагааны 83,153.9 мөнгөн төгрөгийн орлогыг дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилтээр бүртгэсэн. | 1 | 83,153.90 | | | 1 | 83,153.90 | 1 | 83,153.90 | | |
| | **Дүн** | **5** | **926,514.7** | | | **5** | **926,514.7** | **5** | **926,514.7** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | | Үүнээс: Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Бараа үйлчилгээний бусад зардлаас сургалт зохион байгуулж, анхан шатны баримтын бүрдэл дутуу, сургалтын тайлан гаргаагүй зардалд бүртгэсэн. | 1 | 12,193.0 | | | | | 1 | 12,193.0 | | | | |
| 2 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| 3 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 382 ширхэг 173.549.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| | **Нийт дүн** | **3** | **12,193.0** | | | | | **3** | **12,193.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 123 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 25 мэдээлэл, байршуулаагүй 23 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 142,938.6 мянган төгрөгийн 37 гүйлгээ, зарлагын 227,788.9 мянган төгрөгийн 25 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 436,248.1 мянган төгрөгийн 11 гүйлгээ байршуулаагүй. Мөн шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбар болон таван сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг тус тус байршуулаагүй байна. | 1 | 2,093,674.6 | - | - | 1 | 2,093,674.6 | | |
| **Дүн** | **1** | **-** | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Нийт 58,797.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн. | 1 | 58,797.0 | | | | | 1 | 58,797.0 |
| **Дүн** | **1** | **58,797.0** | | | | | **1** | **58,797.0** |
| **Нийт дүн** | **2** | **2,152,471.6** | | | **1** | **2,093,674.6** | **1** | **58,797.0** |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр Дугаар 69-20810579-ТӨА-2026/014/НА-СТА-ТШ3 Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 123 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 25 мэдээлэл, байршуулаагүй 23 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 142,938.6 мянган төгрөгийн 37 гүйлгээ, зарлагын 227,788.9 мянган төгрөгийн 25 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 436,248.1 мянган төгрөгийн 11 гүйлгээ, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбар болон таван сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Заамар сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Баярсайхан, нягтлан бодогч Л.Нямдулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn